



MIK ХОЛДИНГ ХК
MIK HOLDING JSC

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, 13-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19,
Худалдаа хөгжлийн банкны байр, 13-р давхар
Утас: 11-328267, Факс: 11-313338, И-мэйл: info@mik.mn
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот-14210,
Шуудангийн хайрцаг-215

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ"
ТӨХК-Д

2020/01/08 № 20/19
танай _____-ны № _____-т

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай*


Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа "COVID-19"-ийн цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэргт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан билээ.

Иймд гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэртэй уялдуулан компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төвлөсөн хугацаанд буюу 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар боллоо.

Хурлын шинэчлэгдсэн зар болон хувьцаа эзэмшигчдэд зориулсан хуралд оролцож, санал өгөх зааврыг өөрийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ВАХИРАЛ



Б.ГАНТУЛГА

0000104



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр:

“МИК Холдинг” ХК

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Энхтайвны өргөн чөлөө-19,
13-р давхар, Утас: 11328267

Хурал хуралдах огноо, цаг, газар:

2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт компанийн веб сайт болох www.mik.mn-ээр дамжуулан цахим болон зайны технологи ашиглан хуралдуулах.

Бүртгэлийн өдөр:

2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
4. ТУЗ-ийн 2020 оны зардлын төсвийг батлах тухай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хувьцаа эзэмшигчид 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан, эсвэл компанийн байранд ирж Хурал зохион байгуулах комиссын дарга (Г.Саруул)-д мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцаж болно.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гарагт 09:00-16:00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:

Дарга: Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Email: saruul@mik.mn

Утас: 328267 /828/

Гишүүн: А.Анар, Үйл ажиллагааны газрын захирал

Email: anar.a@mik.mn

Утас: 328267 /847/

Гишүүн: Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч

Email: maralmaa@mik.mn

Утас: 328267 /825/

Гишүүн: Ц.Мөнх-Эрдэнэ, Мэдээлэл технологийн хэлтсийн захирал

Email: munkherdene@mik.mn

Утас: 328267 /850/

Нэмэлт мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, саналаа өгөх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголын Хөрөнгийн Бирж /www.mse.mn/ болон компанийн вэб сайт /www.mik.mn/-аас авна уу.



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОЖ, САНАЛ ӨГӨХ ЗААВАР

“МИК Холдинг” ХК нь COVID-19 цар тахлын болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлэх үүднээс 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах тул тус компанийн хувьцаа эзэмшигчид нь хуралд дараах байдлаар оролцож, санал өгөх боломжтой. Үүнд:

- Урьдчилан санал өгөх:

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудад тараасан “Санал авах хуудас”-аар дамжуулан өгөх саналыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 хүртэл хүлээн авах бөгөөд ирүүлсэн санал авах хуудас, баталгаажуулах бичиг баримтыг үндэслэн хувьцаа эзэмшигчийн урьдчилан ирүүлсэн саналыг бүртгэж, хурлын ирцэд тооцно.

Хувьцаа эзэмшигчид “Санал авах хуудас”-ыг бөглөхдөө тус хуудсан дахь санамжтай сайтар танилцана уу.

- Цахим хуралд оролцох:

Хувьцаа эзэмшигч нь цахим хурлын үеэр зөвхөн бүртгүүлсэн гар утасны дугаараас мессеж илгээх замаар саналаа өгөх бөгөөд энэ тохиолдолд дараах алхамыг зайлшгүй хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цаг хүртэлх хугацаанд ажлын өдрийн 08:00-17:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Худалдаа Хөгжлийн Банкны байрны 13-р давхарт дараах бичиг баримттай биечлэн ирж бүртгүүлнэ.
 - Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний үнэмлэх
 - Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд бол итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэх, ажлын үнэмлэх
 - Хувьцаа эзэмшигч нь төлөөллөөр дамжуулан оролцох тохиолдолд энэхүү зааврын хавсралт дахь маягтын дагуу олгосон итгэмжлэл, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх
2. Хурлын өдөр буюу 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр компанийн вэб сайт /www.mik.mn/ дахь **“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ”** цэс рүү нэвтэрч, хуралд оролцоно.
 - Нэвтрэх нэр: Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн регистрийн дугаар байна.
 - Нууц үг: Хувьцаа эзэмшигч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүртгүүлсэн гар утасны дугаарт ирсэн нэг удаагийн нэвтрэх кодыг оруулна.
3. Хувьцаа эзэмшигч нь компанийн тусгай дугаараас хувьцаа эзэмшигчдийн бүртгүүлсэн гар утасны дугаар руу ирсэн зааврын дагуу мессежээр саналаа өгнө.

Нэмэлт мэдээлэл:

- Хурал нээх ирцийг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00-11:20 цагийн хооронд хурлын цэс рүү нэвтэрсэн болон урьдчилан санал авах хуудсыг ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нийт хувьцааны тоогоор тооцно.
- Хурлын тооллогын комисс нь хурлын дэгийн 6-д тусгасан хугацаанд багтаан хурлаар шийдвэрлэх асуудал тус бүрээр санал өгөх хугацааг 5 орчим минутаар тогтоох ба тогтоосон хугацаанд багтаан санал ирүүлээгүй бол тухайн хувьцаа эзэмшигчийг санал өгөөгүйд тооцно.
- Хувьцаа эзэмшигчийн илгээх санал нь 1 бол зөвшөөрсөн, 2 бол түдгэлзсэн, 3 бол татгалзсан гэсэн утгыг илэрхийлэх ба үүнээс өөр тоо, тэмдэгтээр саналаа өгвөл тус саналыг хүчингүйд тооцож, тусгай дугаараас мэдэгдэл хүргүүлнэ. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигч санал авах хугацаанд багтаан зааврын дагуу шинээр саналаа өгөх боломжтой.
- Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр ирцийг 11:00-12:15 цагийн хооронд компанийн вэб сайт дахь цэс рүү нэвтэрсэн болон урьдчилан санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нийт хувьцааны тоогоор тооцно.
- Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцож, санал өгөхтэй холбоотой тодруулах зүйл байвал Хурлын тооллогын комисс (комиссын дарга С.Амарсайхан, 11328267-842)-той холбогдоно уу.

∞ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС ∞



ИТГЭМЖЛЭЛ

/Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд/

Хэнд: “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Огноо: _____ оны _____ сарын _____ өдөр

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан _____ албан ёсны хаягт бүртгэлтэй, _____ регистрийн дугаартай _____ нь “МИК Холдинг” ХК-ийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бидний нэрийн өмнөөс оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр _____ албан тушаалтай _____ /регистрийн дугаар: _____, гар утасны дугаар _____ /-г томилж байна. Тус итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах эрхтэй байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд _____-н нэрийн өмнөөс оролцох;
2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрүүдийн төсөлд _____ -г төлөөлж санал өгөх.

Энэхүү итгэмжлэл нь гагцхүү “МИК Холдинг” ХК-ийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүчинтэй байна.

Энэхүү итгэмжлэлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх болон ажлын үнэмлэхийн хуулбарын хамт хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

/албан тушаал/ /тэмдэг/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

ИТГЭМЖЛЭЛ

/Хувьцаа эзэмшигч иргэн/

Хэнд: “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Огноо: _____ оны _____ сарын _____ өдөр

_____ овогтой _____
/ _____ хаягт оршин суудаг,
_____ регистрийн дугаартай/ би “МИК Холдинг” ХК-ийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд миний нэрийн өмнөөс оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр _____ овогтой _____ /регистрийн дугаар: _____, гар утасны дугаар _____ /-г томилж байна. Тус итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах эрхтэй байна. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд _____-н нэрийн өмнөөс оролцох;
2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрүүдийн төсөлд _____-г төлөөлж санал өгөх.

Энэхүү итгэмжлэл нь гагцхүү “МИК Холдинг” ХК-ийн 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүчинтэй байна.

Энэхүү итгэмжлэлийг хувьцаа эзэмшигчийн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбарын хамт хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/